



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠰᠣᠩᠭᠢᠨᠬᠠᠶᠢᠷᠬᠠᠨ  
ᠳᠦᠦᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ  
ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠳᠡᠷᠭᠡᠳᠡᠬ  
ᠰᠠᠲᠢᠰᠲᠢᠻᠢᠬᠢᠶᠢᠨ  
ᠬᠡᠯᠲᠡᠰ

# НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2021 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРАЛ

Улаанбаатар хот 2021 он


Сонгинохайрхан дүүрэг нь 94297 өрхийн 334912 хүн амтай бөгөөд 2021 оны эхний 9 сард дүүргийн хэмжээнд 1987 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 91(4.8%) хэргээр өссөн байна.Тайлант хугацаанд гарсан нийт гэмт хэргийн 1661(83.6%) нь хөнгөн, 326(16.4%) нь хүнд гэмт хэрэг, 297(14.9%) нь согтуугаар үйлдэгдсэн, 45(2.3%) нь хүүхэд оролцсон, 226(11.4%) нь эмэгтэйчүүд оролцсон, 141(7.1%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн байна.

Хүснэгт 1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн ангилалаар

Үзүүлэлт	Он	Бүх хэрэг	Гэмт хэргийн ангилал		Согтуугаар үйлдэгдсэн	Хүүхэд оролцсон	Эмэгтэйчүүд оролцсон	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас
			хөнгөн	хүнд				
Сонгинохайрхан	2020.09	1896	1377	519	228	79	203	99
I хэлтэс		933	652	281	66	32	72	33
II хэлтэс		512	350	162	65	30	66	21
III хэлтэс		451	375	76	97	17	65	45
Сонгинохайрхан	2021.09	1987	1661	326	297	45	226	141
I хэлтэс		989	819	170	81	22	96	76
II хэлтэс		584	481	103	164	12	78	33
III хэлтэс		414	361	53	52	11	52	32
2021/2020		104.8	120.6	62.8	130.3	57.0	111.3	142.4

2021 оны эхний 9 сард бүртгэгдсэн нийт хэргийн 989(49.8%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 584(29.4%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 414(20.8%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст харьяалагдаж байна.

Дүрслэл 1. Гэр бүлийн хүчирхийлэлд автсан хохирогчийн тоо, дүүргээр



Тайлант хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт гэр бүлийн хүчирхийллийн 141 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 42 (42.4%) хэргээр өссөн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 105 хүн хохирсон байна.


2021 оны гуравдугаар улиралд нийслэл хотод нийт 11132 хэрэг бүртгэгдсэний 17.8 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт ногдож байна. Нийслэл хотод гарсан нийт хэргийн 9943(89.3%) хөнгөн гэмт хэрэг, 1189(10.7%) хүнд гэмт хэрэг байна. Нийслэлд гарсан нийт хөнгөн гэмт хэргийн 16.7 хувь, хүнд гэмт хэргийн 27.4 хувь нь тус дүүрэгт ногдож байна.

## Хүснэгт 2.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, дүүргээр

Дүүрэг	Бүх хэрэг			Гэмт хэргийн ангилал					
				Хөнгөн			Хүнд		
	2020.09	2021.09	өөрчлөлт	2020.09	2021.09	өөрчлөлт	2020.09	2021.09	өөрчлөлт
Нийслэл	12350	11132	90.1	10464	9943	95.0	1886	1189	63.0
Баянгол	1940	1774	91.4	1812	1680	92.7	128	94	73.4
Баянзүрх	3324	2791	84.0	2868	2470	86.1	456	321	70.4
Сүхбаатар	2065	1578	76.4	1781	1224	68.7	284	154	54.2
Сонгинохайрхан	1896	1987	104.8	1377	1661	120.6	519	326	62.8
Хан-уул	1252	1406	112.3	1075	1279	119.0	177	127	71.8
Чингэлтэй	1453	1252	86.2	1192	1131	94.9	261	121	46.4
Багануур	115	120	104.3	97	107	110.3	18	13	72.2
Багахангай	18	14	77.8	17	12	70.6	1	2	2 дах
Налайх	287	210	73.2	245	179	73.1	42	31	73.8

2021 оны гуравдугаар улиралд нийслэл хотод 11132 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 1218(9.9%) хэргээр буурсан байна. Нийт гарсан хэргийн 1774(15.9%) нь Баянгол, 2791(25.1%) нь Баянзүрх, 1578(14.2%) нь Сүхбаатар, 1987(17.8%) нь Сонгинохайрхан, 1406(12.6%) нь Хан-уул, 1252(11.2%) нь Чингэлтэй, 120(1.1%) нь Багануур, 14(0.1%) нь Багахангай, 210(1.9%) нь Налайх дүүрэгт тус тус гарсан байна.

### Дүрслэл 2. Гэмт хэргийн тоо, дүүргээр



Хүснэгт 3. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн ангиллаар

Үзүүлэлт	Он	хүний амьд явах эрхийн эсрэг			хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг				хүний бэлгийг эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	
		Хүнийг алах	хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх		хүний эрүүл мэндэд халдашгүй байдлын эсрэг	хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		хүчиндэх
Сонгинохайрхан	2020.09	41	26	12	625	24	561	8	51	47
I хэлтэс		17	10	5	306	8	279	5	24	23
II хэлтэс		14	9	5	159	10	135	3	20	19
III хэлтэс		10	7	2	160	6	147	0	7	5
Сонгинохайрхан	2021.09	47	20	22	752	29	665	14	50	44
I хэлтэс		24	10	10	363	13	322	7	31	28
II хэлтэс		14	7	7	225	8	204	3	12	11
III хэлтэс		9	3	5	164	8	139	4	7	5
2021/2020		114.6	76.9	183.3	120.3	120.8	118.5	175.0	98.0	93.6


Оны эхний 9 сард Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт хэргийн 47(2.3%) нь хүний амьд явах эрхийн эсрэг, 752(42.6%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 50 (2.6%) нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, 12(0.7%) нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг, 22(2.0%) нь эдийн засгийн, 22(2.0%) нь олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг, 2(0.1%) нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг, 4(0.3%) нь нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг, 8(0.4%) нь хүрээлэн байгаа байгаль орчны эсрэг, 5(0.4%) нь цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, 4(0.4%) нь хүүхдийн эсрэг, 70(3.8%) нь хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслэлийн ашиглалтын журмын эсрэг хэргүүд байна.

Хүснэгт 3- ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Он	хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг		хүүхдийн эсрэг	эдийн засгийн	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг	хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг	хүрээлэн байгаа байгаль орчны эсрэг	цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслэлийн ашиглалтын журмын эсрэг
		Заналхийлэх									
Сонгинохайрхан	2020.09	7	1	1	3	20	2	10	10	3	71
I хэлтэс		4	1	1	1	13	1	3	8	1	35
II хэлтэс		0	0	0	1	3	1	3	0	2	24
III хэлтэс		3	0	0	1	4	0	4	2	0	12
Сонгинохайрхан	2021.09	12	1	4	22	25	2	4	8	5	70
I хэлтэс		9	0	0	8	7	1	4	7	1	44
II хэлтэс		3	1	1	12	9	1	0	1	3	20
III хэлтэс		0	0	3	2	9	0	0	0	1	6
2021/2020		171.4	100.0	4дах	7.3 ах	125.0	100.0	40.0	80.0	166.7	98.6

2021 оны гуравдугаар улирлын байдлаар өмчлөх эрхийн эсрэг хэрэг 986(68.4%) гарсан нь өмнөх оны мөн үеэс 64(6.1%) хэргээр буурсан байна.Тайлант хугацаанд нийт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 412(41.8%) нь хулгайлах гэмт хэрэг, 60(6.1%) нь дээрэмдэх, 383(38.8%) нь залилах, 29(2.9%) нь хөрөнгө завших, 26(2.6%) нь эд хөрөнгө устгах гэмтээх, 13(1.3%) нь мал хулгайлах хэрэг байна. Хулгайлах гэмт хэргийн 388(94.2%) нь хувийн өмч хулгайлах, 3(1.6%) нь халаасны хулгайн гэмт хэрэг байна. Хувийн өмч хулгайлах гэмт хэргийн 13(3.4%) нь автотээврийн хэрэгслэл хулгайлах гэмт хэрэг байна. Оны эхний 9 сард бүртгэгдсэн нийт хулгайлах гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 37.2 хувиар, дээрэм 9.1 хувиар, малын хулгай 43.5 хувиар, авто тээврийн хэрэгслэл зөвшөөрөлгүй авч явах хэрэг 7.1 хувиар тус тус буурсан бол халаасны хулгай 2 дахин, эд хөрөнгө устгах гэмтээх хэрэг 36.8 хувиар, залилах гэмт хэрэг 62.3 хувиар, хөрөнгө завших гэмт хэрэг 61.1хувиар тус тус нэмэгдсэн байна.

Дүрслэл 3. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдлаар, дүүргээр




Хүснэгт 4. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо

Үзүүлэлт	Он	Өмчлөх эрхийн эсрэг	Өмчлөх эрхийн эсрэг				Дээрэмдэх	Залилах	Хөрөнгө завших	эд хөрөнгө устгах, Гэмтээх	мал хулгайлах
			Хулгайлах	Хувийн өмч хулгайлах	Автотээврийн хэрэгслэл хулгайлах	Халаасны хулгай					
Сонгинохайрхан	2020.09	1050	656	633	14	4	66	236	18	19	23
I хэлтэс		517	345	329	10	3	26	90	8	10	23
II хэлтэс		285	180	179	1	0	14	68	4	7	0
III хэлтэс		248	131	125	3	1	26	78	6	2	0
Сонгинохайрхан	2021.09	986	412	388	13	8	60	383	29	26	13
I хэлтэс		490	205	189	11	3	22	197	13	5	12
II хэлтэс		283	125	121	2	1	16	101	7	16	1
III хэлтэс		213	82	78	0	4	22	85	9	5	0
2021/2020		93.9	62.8	61.3	92.9	2 дах	90.9	162.3	161.1	136.8	56.5

Тайлант хугацаанд гарсан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 490(49.7%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст,283(28.7%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 213(21.6%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус харьяалагдаж байна.

Дүрслэл 4. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, дүүргээр



2021 оны гуравдугаар улирлын байдлаар Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт хэргийн 307(14.5%) нь Даваа гарагт, 313(16.3%) нь Мягмар гарагт, 281(15.0%) нь Лхагва гарагт, 306(16.3%) нь Пүрэв гарагт, 299(14.6%) нь Баасан гарагт, 246(11.7%) нь Бямба гарагт, 235(11.6%) нь Ням гарагт тус тус гарсан байна. Мягмар гарагт хамгийн их хэрэг гарсан бөгөөд Бямба, Ням гарагт хамгийн бага хэрэг гарчээ. Гарсан гэмт хэргийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал Даваа гарагт гарсан хэрэг 1.7 хувиар, Мягмар гарагт гарсан хэрэг 15.9 хувиар, Лхагва гарагт гарсан хэрэг 1.1 хувиар, Пүрэв гарагт гарсан хэрэг 8.1 хувиар, Бямба гарагт гарсан хэрэг 6.0 хувиар, Ням гарагт гарсан хэрэг 1.7 хувиар тус тус нэмэгдсэн бол Баасан гарагт гарсан хэрэг 0.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 5. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэрэг үйлдэгдсэн гарагаар

Үзүүлэлт	Он	Гараг						
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
Сонгинохайрхан	2020.09	302	270	278	283	300	232	231
I хэлтэс		151	135	145	138	155	97	112
II хэлтэс		83	61	68	87	77	79	57
III хэлтэс		68	74	65	58	68	56	62
Сонгинохайрхан	2021.09	307	313	281	306	299	246	235
I хэлтэс		154	161	140	156	161	119	98
II хэлтэс		88	89	70	88	80	83	86
III хэлтэс		65	63	71	62	58	44	51
2021/2020		101.7	115.9	101.1	108.1	99.7	106.0	101.7

Тайлант хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн 605(30.4%) нь 06-14 цагийн хооронд, 597(30.0%) нь 14-19 цагийн хооронд, 304(15.3%) нь 19-22 цагийн хооронд, 481(24.2%) нь 22-06 цагийн хооронд тус тус гарсан байна. Тайлант хугацаанд гарсан хэргийн байдлаас харахад 06-14 цагийн хооронд хамгийн их хэрэг гарсан бол 19-22 цагийн хооронд хамгийн бага хэрэг гарсан байна. 06-14 цагийн хооронд гарсан гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 24.0 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэг үйлдэгдсэн цагаар

Үзүүлэлт	Он	Цаг			
		06-14	14-19	19-22	22-06
Сонгинохайрхан	2020.09	488	612	305	491
I хэлтэс		250	284	138	261
II хэлтэс		133	193	78	108
III хэлтэс		105	135	89	122
Сонгинохайрхан	2021.09	605	597	304	481
I хэлтэс		340	267	147	235
II хэлтэс		150	188	99	147
III хэлтэс		115	142	58	99
2021/2020		124.0	97.5	99.7	98.0

2021 оны эхний 9 сард бүртгэгдсэн нийт хэргийн 966(24.5%) нь гэр орон сууцанд гарсан хэрэг бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 87(9.9%) хэргээр өссөн байна. Тайлант хугацаанд нийт гэр орон сууцанд гарсан хэргийн 389(40.3%) нь гэрт, 171(17.7%) нь орон сууцны байранд, 275(28.5%) нь хувийн байшинд, 26(2.7%) нь зуслангийн байшинд, 55(5.7%) нь нийтийн байранд, 10(1.0%) нь орцонд тус тус гарсан байна.

Тайлант хугацаанд нийт гэр, орон сууцанд гарсан хэргийн 456(47.2%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 323(33.4%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 187(19.4%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

Хүснэгт 7. Гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэрэг

Үзүүлэлт	Он	гэр, орон сууц						
			гэр	орон сууцны байр	хувийн байшин	зуслангийн байшин	нийтийн байр	орц
Сонгинохайрхан	2020.09	879	398	133	247	20	29	17
I хэлтэс		422	192	50	129	12	7	5
II хэлтэс		279	154	21	84	8	8	0
III хэлтэс		178	52	62	34	0	14	12
Сонгинохайрхан	2021.09	966	389	171	275	26	55	10
I хэлтэс		456	192	71	138	16	22	2
II хэлтэс		323	158	23	103	9	12	0
III хэлтэс		187	39	77	34	1	21	8
2021/2020		109.9	97.7	128.6	111.3	130.0	189.7	58.8

Тайлант оны эхний 9 сард гудамж тайлбайд 414 хэрэг гарсан нь Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт хэргийн 20.8 хувь болж байна. Тайлант хугацаанд гудамж тайлбайд гарсан нийт хэргийн 174(42.0%) нь гэр хорооллын гудамжинд, 87(21.0%) нь орон сууцны гудамжинд, 40(9.7%) нь ил зогсоол дээр,

41(9.9%) нь автобусын буудал дээр тус тус гарсан байна. Тайлант хугацаанд гудамж талбайд гарсан хэрэг өмнөх оны мөн үеэс 78(23.2%) хэргээр өссөн бөгөөд нийт гудамж, талбайд гарсан хэргийн 168(40.6%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 124(29.9%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 122(29.5%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

Хүснэгт 8. Гудамж, талбайд үйлдэгдсэн хэрэг

Үзүүлэлт	Он	Гудамж, талбай				
			гэр хорооллын гудамж	орон сууцны хороололын гудамж	ил зогсоол	автобусны буудал
Сонгинохайрхан	2020.09	336	119	85	35	36
I хэлтэс		82	28	17	10	10
II хэлтэс		113	59	2	8	11
III хэлтэс		141	32	66	17	15
Сонгинохайрхан	2021.09	414	174	87	40	41
I хэлтэс		168	64	36	17	15
II хэлтэс		124	80	11	1	11
III хэлтэс		122	30	40	22	15
2021/2020		123.2	146.2	102.4	114.3	113.9

2021 оны эхний 9 сард олон нийтийн газарт 91 хэрэг бүртгэгдсэн нь нийт хэргийн 4.6 хувийг эзэлж байгаа бөгөөд олон нийтийн газарт гарсан нийт хэргийн 16(17.6%) нь дэлгүүрт, 13(14.3%) нь зочид буудалд, 7(7.7%) нь бааранд, 2(2.2%) нь ресторан зоогийн газарт, тус тус гарсан байна. Тайлант хугацаанд олон нийтийн газарт гарсан хэрэг өмнөх оны мөн үеэс 30(24.8%) хэргээр буурсан нийт олон нийтийн газарт гарсан хэргийн 22(24.2%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 23(25.3%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 46(50.5%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

Хүснэгт 9. Олон нийтийн газарт үйлдэгдсэн хэрэг

Үзүүлэлт	Он	Олон нийтийн газар					
			дэлгүүр	зочид буудал	баар	ресторан, зоогийн газар	амралтын газар
Сонгинохайрхан	2020.09	121	13	14	14	9	4
I хэлтэс		42	2	5	3	2	3
II хэлтэс		27	6	3	1	0	1
III хэлтэс		52	5	6	10	7	0
Сонгинохайрхан	2021.09	91	16	13	7	2	0
I хэлтэс		22	3	4	0	0	0
II хэлтэс		23	5	3	3	0	0
III хэлтэс		46	8	6	4	2	0
2021/2020		75.2	123.1	92.9	50.0	22.2	0.0

2021 оны эхний 9 сард нийтийн тээвэрт 8 хэрэг гарсан нь өмнөх оноос 10(55.6%) хэргээр буурсан байна. Тайлант хугацаанд нийтийн тээвэрт гарсан гэмт хэргийн 2(25.0%) нь том оврын автобусанд, 4(50.0%) нь таксид гарсан бол дунд оврын болон микро автобусанд хэрэг гараагүй байна. Таксид гарсан хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 3(42.9%) хэргээр буурсан байна.




## Хүснэгт 10. Нийтийн тээвэрт үйлдэгдсэн хэрэг

Үзүүлэлт	Он	нийтийн тээвэр			
		том оврын автобус	дунд оврын автобус	такси	
Сонгинохайрхан	2020.09	18	5	2	7
I хэлтэс		4	0	1	1
II хэлтэс		0	0	0	0
III хэлтэс		14	5	1	6
Сонгинохайрхан	2021.09	8	2	0	4
I хэлтэс		3	1	0	1
II хэлтэс		1	0	0	0
III хэлтэс		4	1	0	3
2021/2020		44.4	40.0	0.0	57.1

2021 оны эхний 9 сард нийтийн тээвэрт гарсан хэргийн 3(37.5%) цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 1 (12.5%) цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 4(50.0%) цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

### Дүрслэл 5. Хэрэг үйлдэгдсэн байршил, дүүргээр



2021 оны эхний 9 сард Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт хэргийн 120(6.0%) нь аж ахуйн нэгжид, 9(0.5%) нь төрийн байгууллагад, 3(0.2%) нь төрийн бус байгууллагад, 72(3.6%) нь авто зам дээр, 304(15.3%) бусад газарт тус тус гарсан байна. Тайлант хугацаанд аж ахуйн нэгжид гарсан хэргийн 63(52.5%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 22(18.3%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 35(29.2%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст гарсан байна. Төрийн байгууллагад гарсан хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 3(50.0%) хэргээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 11. Хэрэг үйлдэгдсэн газар, өмчийн хэлбэрээр

Үзүүлэлт	Он	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Аж ахуйн нэгж	Авто зам	Бусад
Сонгинохайрхан	2020.09	6	9	124	71	332
I хэлтэс		4	5	51	36	287
II хэлтэс		1	4	56	23	39
III хэлтэс		1	0	47	12	6
Сонгинохайрхан	2021.09	<b>9</b>	<b>3</b>	<b>120</b>	<b>72</b>	<b>304</b>
I хэлтэс		3	2	63	46	226
II хэлтэс		2	1	22	20	68
III хэлтэс		4	0	35	6	10
2021/2020		150.0	33.3	96.8	101.4	91.6

2021 оны эхний 9 сард хэрэг үйлдсэн хүний тоо 1193 байсан нь өмнөх оны мөн үеэс 59(5.2%) хүнээр өссөн байна. Хэрэг үйлдсэн нийт хүний 184(15.4%) нь эмэгтэй, 17(1.4%) нь 15 хүртэлх насны, 30(2.5%) нь 16-17 настай, 253(21.2%) нь 18-24 настай, 175(14.7%) нь 25-29 настай, 241(20.2%) нь 30-34 настай, 146(12.2%) нь 35-39 настай, 119(9.9%) нь 40-44 настай, 75(6.3%) нь 45-49 настай, 77(6.4%) 50-54 настай, 41(3.4%) нь 55-59 настай, 19(1.6%) нь 60 аас дээш настай байна. Хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 21(12.9%) хүнээр, 60 болон түүнээс дээш насны хүн 6(46.2%) - оор нэмэгдэж, 15 хүртэлх насны хүүхдийн тоо 27(61.4%) - ээр буурсан байна.

Тайлант хугацаанд хэрэг үйлдсэн нийт хүний 573(48.0%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 341(28.6%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 279(23.4%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст харьяалагдаж байна.

Хүснэгт 12.Хэрэг үйлдэгсэд, насны бүлгээр

Үзүүлэлт	Сонгинохайрхан				Сонгинохайрхан				2021 2020	
	Нийт	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	Нийт	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс		
Он	2020.09				2021.09					
Бүх хүн	1134	550	287	297	1193	573	341	279	105.2	
Эмэгтэй	163	60	53	50	184	86	61	37	112.9	
Насны бүлэг	15 хүртэлх	44	18	15	11	17	10	2	5	38.6
	16-17	51	23	17	11	30	14	9	7	58.8
	18-24	223	104	67	52	253	108	81	64	113.5
	25-29	243	114	52	77	175	83	49	43	72.0
	30-34	181	79	55	47	241	129	60	52	133.1
	35-39	134	67	28	39	146	64	41	41	109.0
	40-44	104	58	20	26	119	55	38	26	114.4
	45-49	70	37	18	15	75	41	18	16	107.1
	50-54	47	28	9	10	77	39	28	10	163.8
	55-59	24	15	4	5	41	25	8	8	170.8
60+	13	7	2	4	19	5	7	7	146.2	

Оны эхний 9 сарын байдлаар хэрэг үйлдсэн нийт хүний 27(2.3%) нь төрийн албан хаагч, 75(6.3%) нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 21(1.8%) нь төрийн бус байгууллагад ажиллагч, 313 (26.2%) нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 7(0.6%) нь малчин, 11(0.9%) нь оюутан, 18(1.5%) нь сурагч, 11(0.9%) нь сургууль завсардсан буюу тэнэмэл хүүхэд, 9(0.8%) нь хоригдол, 701(58.8%) нь ажилгүй иргэн байна. Тайлант хугацаанд хэрэг үйлдсэн ажилгүй иргэн өмнөх оны мөн үеэс 66(10.4%) -оор өссөн байна.

Хүснэгт 13. Хэрэг үйлдэгсэд, нийгмийн байдлаар

Үзүүлэлт	Он	Төрийн албан хаагч	Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч	Төрийн бус байгууллагын ажилтан	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Малчин	Оюутан	Сурагч	Сургууль завсардсан хүүхэд, тэнэмэл хүүхэд	Хоригдол	Ажилгүй
Сонгинохайрхан	2020.09	22	80	11	290	25	14	30	23	4	635
I хэлтэс		16	22	5	168	22	4	15	7	0	291
II хэлтэс		1	7	2	65	0	3	9	7	4	189
III хэлтэс		5	51	4	57	3	7	6	9	0	155
Сонгинохайрхан	2021.09	27	75	21	313	7	11	18	11	9	701
I хэлтэс		12	37	4	176	6	5	8	1	3	321
II хэлтэс		5	7	6	81	0	4	4	2	6	226
III хэлтэс		10	31	11	56	1	2	6	8	0	154
2021/2020		122.7	93.8	190.9	107.9	28.0	78.6	60.0	47.8	225.0	110.4

Хэрэг үйлдсэн нийт хүний 21(1.8%) нь боловсролгүй, 61(5.1%) нь бага боловсролтой, 203(17.0%) нь суурь боловсролтой, 726(60.9%) нь бүрэн дунд боловсролтой, 67(5.6%) нь тусгай мэргэжилийн дунд боловсролтой, 115(10.9%) нь дээд боловсролтой байна.

Хүснэгт 14. Хэрэг үйлдэгсэд, боловсролын түвшингээр

Үзүүлэлт	Он	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
Сонгинохайрхан	2020.09	26	108	266	567	28	139
I хэлтэс		6	52	154	275	11	52
II хэлтэс		11	21	63	163	4	25
III хэлтэс		9	35	49	129	13	62
Сонгинохайрхан	2021.09	21	61	203	726	67	115
I хэлтэс		11	18	107	362	35	40
II хэлтэс		4	33	49	212	14	29
III хэлтэс		6	10	47	152	18	46
2021/2020		80.8	56.5	76.3	128.0	239.3	82.7

Тайлант хугацаанд гэмт хэргийн улмаас хохирсон 1974 иргэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 95(5.1%)- хүнээр нэмэгдсэн бөгөөд 917(46.5%) нь эмэгтэй байна. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 45(10.9%) 13 хүртэлх насны хүүхэд, 61(10.9%) 14-17 насны, 229(10.9%) 18-24 насны, 274(10.9%) 25-29 насны, 370(10.9%) 30-34 насны, 286(10.9%) 35-39 насны, 238(10.9%) 40-44 насны, 169(10.9%) 45-49 насны, 138(10.9%) 50-54 насны, 74(10.9%) 55-59 насны, 90(10.9%) нь 60, түүнээс дээш насны хүн ам байна.

Хүснэгт 15. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, насны бүлгээр

Үзүүлэлт	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	<u>2021</u> 2020
Он	2020.09				2021.09				
Нийт хохирсон иргэн	1879	993	433	453	1974	1065	501	408	105.1
эмэгтэй	856	424	223	209	917	477	251	189	107.1
13 хүртэл настай	44	29	10	5	45	23	12	10	102.3
14-17	58	33	11	14	61	37	13	11	105.2
18-24	221	100	60	61	229	115	59	55	103.6
25-29	252	113	62	77	274	153	67	54	108.7
30-34	369	187	77	105	370	195	92	83	100.3
35-39	263	161	47	55	286	154	67	65	108.7
40-44	201	108	50	43	238	129	68	41	64.2
45-49	170	90	43	37	169	88	49	32	99.4
50-54	121	68	30	23	138	70	39	29	114.0
55-59	82	51	19	12	74	50	16	8	90.2
60+	98	53	24	21	90	51	18	20	91.8

2021 оны эхний 9 сард гарсан гэмт хэргийн улмаас 7808.3 сая төгрөгийн хохирол учирсан нь өнгөрсөн оны мөн үеэс 758.1(8.8%) сая төгрөгөөр буурсан байна. Хөнгөн гэмт хэргийн улмаас учирсан хохирол 6090.1 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 464.4(6.5%) сая төгрөгөөр нэмэгдсэн бол хүнд гэмт хэргийн улмаас учирсан хохирол 1222.5(63.4%) сая төгрөгөөр багассан байна.

Хүснэгт 16. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, сая төгрөгөөр

Үзүүлэлт	Он	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол / сая төгрөг/			хохирол нөхөн төлүүлэлт	
		хөнгөн	хүнд	сая төгрөг	хувиар	
Сонгинохайрхан	2020.09	8566.4	5625.7	2940.7	3243.7	37.9
I хэлтэс		4161.6	2351.5	1810.1	814.8	19.6
II хэлтэс		2562.7	2240.4	322.3	1694.2	66.1
III хэлтэс		1842.1	1033.9	806.2	734.7	39.9
Сонгинохайрхан	2021.09	7808.3	6090.1	1718.2	3443.6	44.1
I хэлтэс		5751.9	4363	1388.8	2318.7	40.3
II хэлтэс		1187.1	988.6	198.5	649.3	54.7
III хэлтэс		869.3	738.5	130.8	475.6	54.7
2021/2020		91.2	108.3	58.4	106.2	116.4

Тайлант хугацаанд 41781 зөрчил бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2.7 дахин их зөрчлөөр нэмэгдсэн байна.Энэ нь цагдаагийн газрын бүтцийн өөрчлөлтэй холбоотой гэж үзэж байна. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 29991(71.8%) нь ердийн журмаар шийдвэрлэсэн, 11790(28.2%) нь хялбаршуулсан журмаар шалгасан зөрчил байна.

Хүснэгт 17. Бүртгэгдсэн зөрчлийн тоо

Үзүүлэлт	Он	нийт зөрчил		
			ердийн журмаар шийдвэрлэсэн	хялбаршуулсан журмаар шалгасан
Сонгинохайрхан	2020.09	15236	9801	5435
I хэлтэс		6380	4199	2181
II хэлтэс		3864	2216	1648
III хэлтэс		4992	3386	1606
Сонгинохайрхан	2021.09	41781	29991	11790
I хэлтэс		5462	2025	3437
II хэлтэс		4973	1579	3394
III хэлтэс		10349	8487	1862
Замын цагдаагийн хэлтэс		20997	17900	3097
2021/2020		2.7 дахин	3 дахин	2.2 дахин

Сонгинохайрхан дүүрэгт 2021 оны эхний 9 сард гарсан нийт зөрчлийн 5462(40.4%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 4973(22.2%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 10349(37.4%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст, 20997(50.3%) нь замын цагдаагийн хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

*Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэст эмхэтгэн гаргав.*



## ХОТЫН СОЁЛ ИРГЭН ТАНААС ЭХЭЛНЭ

Улаанбаатар  
**СОЁЛТОЙ  
БОЛГОЁ**  
#ХАМТДАА



Нийтийн тээврээр зорчихдоо ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн иргэдэд суудал тавьж өгч хэвшээрэй

Та олон нийтийн газраар зорчихдоо амны хаалтыг заавал хэрэглэж, бусдынхаа болон өөрийн эрүүл мэндэд анхаараарай



Та унадаг дугуй унахад хориглосон замаар зорчихдос явган зорчигчдийг хүндлэн дугуйгаа хажуудаа хөтлөн зорчоорой

Та авто машинаар хөдөлгөөнд оролцохдоо ч явган хөдөлгөөнд оролцохдоо ч хэзээд гудамж талбайд хогоо ил задгай бүү хаяаарай



Улаанбаатар  
Соёлтой  
Болгоё  
Хотын соёл  
Танаас эхэлнэ

**WWW.1212.MN** СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах  
ТОГЛООМ 

Валютын ханш 



©2017

аппликейшнаас

**СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭ АВААРАЙ**

**Data lab** | тооллого судалгааны  
микро мэдээллийн сан




**Social network**

 [www.facebook.com/StatisticMongolia/](http://www.facebook.com/StatisticMongolia/)


 [www.twitter.com/statistic\\_mn](http://www.twitter.com/statistic_mn)

**Лавлах утас**



**1900-1212**

**Цахим шуудан**



[information@nso.mn](mailto:information@nso.mn)